



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 19 өдөр

Дугаар А/45

Чойр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдаас Аймгийн Засаг даргатай 2022 онд байгуулсан гэрээний 49 дахь заалт, "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан арга хэмжээнүүдийг 2022 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсвийн задаргааг батлах тухай Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/73 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Барилга, байгууламжийг паспортжуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Б.Даваажаргал

(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

З.Эрдэнэзолбоо

(Аймгийн Онцгой байдлын газрын Гамшгийн эрсдлийн удирдлага үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, ахлах дэслэгч)

Нарийн бичиг:

А.Алтаншагай

(Аймгийн ерөнхий архитектор)

2.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Б.Даваажаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА.  Д.СОДНОМ

